

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийгмийн халамжийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/006/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням
Утас:329871 Цахим хаяг:Sambuunyamy@audit.gov.mn
Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,
Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цогбаяр
Утас: 261628 Цахим хаяг: Tsogbayra@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Бүжинханд
Утас: 262071 Цахим хаяг: Vujinkhandj@audit.gov.mn
Аудитор: С.Болортуяа
Утас: 262071 Цахим хаяг: bolortuyas@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА З.ЭНХБОЛД ТАНАА

2025. 03. 25 № 01/1208
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Нийгмийн халамжийн сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн халамжийн сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийгмийн халамжийн үйлчилгээ болгон олгохоор шийдвэрлэсний дагуу 1,303,997 хүүхдэд нийт 1,540,026.3 сая төгрөгийн тэтгэмжийг олгосон нь нийгмийн халамжийн сангийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн үйлчилгээний зардлын 66.9 хувийг эзэлж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу халамжийн сангаас 72 төрлийн 18 хөтөлбөрийн халамжийн үйлчилгээнд нийт 2,679,658 иргэнд нийт 2,299,000.5 сая

төгрөг, үйл ажиллагааны зардалд 1,131.1 сая төгрөг, нийт 2,300,131.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр “Ахмад настны тухай” хуулийн нэмэлт өөрчлөлтийг баталж, хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын 4 журам, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар 3 журам, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар жишиг үнэ шинэчлэн баталсан.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу 78 илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САМБУУНЯМ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/төгрөгөөр/ Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	33,293,200.00	8,603,200.00
2	АВЛАГА	33,293,200.00	8,603,200.00
3	Төлбөртэй үйлчилгээний авлага	7,603,200.00	7,603,200.00
4	Татаас санхүүжилтийн авлага	12,990,000.00	-
5	Бусад авлага	12,700,000.00	1,000,000.00
6	Хувь хүмүүсээс авах авлага	12,700,000.00	1,000,000.00
8	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	33,293,200.00	8,603,200.00
9	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,100,000.00	-
10	Өглөг	1,100,000.00	-
11	Хувь хүмүүст өгөх өглөг	1,100,000.00	-
12	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,100,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	32,193,200.00	8,603,200.00
51	Засгийн газрын оролцоо	32,193,200.00	8,603,200.00
13	Хуримтлагдсан үр дүн	32,193,200.00	8,603,200.00
14	Өмнөх үеийн үр дүн	26,930,200.00	8,603,200.00
15	Тайлант үеийн үр дүн	5,263,000.00	-
16	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	33,293,200.00	8,603,200.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,217,389,291,070.59	2,352,226,330,562.63
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	877,145,532.59	358,420,962.63
120	Нийтлэг татварын бус орлого	877,145,532.59	358,420,962.63
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	877,145,532.59	358,420,962.63
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	877,145,532.59	358,420,962.63
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,216,512,145,538.00	2,351,867,909,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,209,031,220,500.00	2,351,867,909,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,209,031,220,500.00	2,351,867,909,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,480,925,038.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,217,384,028,070.59	2,352,226,330,562.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,217,384,028,070.59	2,352,226,330,562.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,073,865,568.15	1,131,157,907.49
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,060,593,968.15	1,116,630,007.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,060,533,968.15	1,106,630,007.49
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	60,000.00	10,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,271,600.00	14,527,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,271,600.00	14,527,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,216,310,162,502.44	2,351,095,172,655.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,125,324,894,770.45	2,299,000,426,655.54
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	10,665,600.00	-
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,125,314,229,170.45	2,299,000,426,655.54

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	90,985,267,731.99	52,094,745,999.60
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	90,082,760,899.99	51,772,759,686.97
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	36,616,900.00	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	865,889,932.59	321,986,312.63
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	5,263,000.00	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	5,263,000.00	-

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/ төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,217,408,618,070.59	2,352,246,456,696.63
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	877,145,532.59	366,147,096.63
120	Нийтлэг татварын бус орлого	877,145,532.59	366,147,096.63
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	877,145,532.59	359,010,962.63
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	877,145,532.59	359,010,962.63
120008	Төвлөрүүлэх шилжүүлэг /Урсгал/		7,136,134.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,216,531,472,538.00	2,351,880,309,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,209,031,220,500.00	2,351,867,909,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,209,031,220,500.00	2,351,867,909,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,500,252,038.00	12,400,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,217,408,618,070.59	2,352,246,456,696.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,217,408,618,070.59	2,352,246,456,696.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,073,865,568.15	1,138,294,041.49
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,060,593,968.15	1,123,766,141.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,060,533,968.15	1,113,766,141.49
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	60,000.0	10,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,271,600.00	14,527,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,271,600.00	14,527,900.00
21	Урсгал шилжүүлэг	2,216,334,752,504.44	2,351,108,162,655.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,125,325,829,170.45	2,299,013,416,655.54
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,125,325,829,170.45	2,299,013,416,655.54
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	91,008,923,331.99	52,094,745,999.60
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	90,083,350,899.40	51,772,759,686.97
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	49,016,900.00	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	876,555,532.59	321,986,312.63
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	26,930,200.00	26,930,200.00
2	Тайлант үеийн үр дүн	-	-	5,263,000.00	5,263,000.00
3	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	32,193,200.00	32,193,200.00
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(23,590,000.00)	(23,590,000.00)
5	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
6	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	8,603,200.00	8,603,200.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,351,867,909,600.00	2,300,131,584,563.03	51,736,325,036.97	97.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,351,867,909,600.00	2,300,131,584,563.03	51,736,325,036.97	97.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,328,294,800.00	1,131,157,907.49	197,136,892.51	85.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,313,766,900.00	1,116,630,007.49	197,136,892.51	85.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,151,604,800.00	1,106,630,007.49	44,974,792.51	96.1
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	162,162,100.00	10,000,000.00	152,162,100.00	6.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,527,900.00	14,527,900.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,527,900.00	14,527,900.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,350,539,614,800.00	2,299,000,426,655.54	51,539,188,144.46	97.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,350,539,614,800.00	2,299,000,426,655.54	51,539,188,144.46	97.8
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,350,539,614,800.00	2,299,000,426,655.54	51,539,188,144.46	97.8

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,351,867,909,600.00	2,300,131,584,563.03	51,736,325,036.97	97.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,351,867,909,600.00	2,300,095,149,913.03	51,772,759,686.97	97.8
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,351,867,909,600.00	2,300,095,149,913.03	51,772,759,686.97	97.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	36,434,650.00	-	-
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	36,434,650.00	-	-

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	12,400,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	12,400,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	12,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	12,400,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	12,400,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	12,400,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	12,400,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	12,400,000.00

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 1,992,881.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 30.9 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 507.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1,992,343.5 сая төгрөгийн албан шаардлага өгсөн.

Аудитаар нийт 30.9 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуул-сан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэмэлт санхүүжилтийн дансанд данс андуурч орсон 30,930.0 мянган төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд нэмэлт үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор бүртгэсэн.	1	30,930.0	-	-	1	30,930.0	1	30,930.0	-	-	-	-
Дүн	1	30,930.0	-	-	1	30,930.0	1	30,930.0	-	-	-	-

3.2. Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 507.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 507.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлж, албан шаардлага өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд асрамжийн төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх 2 багц ажил үйлчилгээний нээлттэй тендер сонгон шалгаруулалтыг зарлаж, “Батгэрэлт ирээдүй”, “Ачлалт хүүхдүүд” нийгэмд үйлчлэх	1	497,478.6	-	-	1	497,478.6	-	-	-	-	-	-

Нийгмийн халамжийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

<p>өрийн бус байгууллагууд шалгарч нийт 464,557.2 мянган төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг 2024 оны 7 дугаар сарын 01-ний өдөр байгуулсан байна.</p> <p>Тайлант онд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 9 дүгээр сарын 28-ний өдрийн А/130 дугаар тушаалаар шинэчлэн баталсан зардлын нормативаар тооцоогүйгээс гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан гэрээний дүнг 497,478.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн шууд худалдан авалт хийсэн байна.</p>												
<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын /хуучин нэрээр/ 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01/333 тоот албан бичгийг хэрэгжүүлэхдээ нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулаагүй, Сангийн сайдын А/229 дүгээр тушаалаар баталсан журмыг шууд хуулбарлан 2024 оны 12 дугаар сарын 23-нд аж ахуйн нэгжтэй ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, 150 ширхэг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хэвлүүлэх зардалд нийт 19,200.0 мянган төгрөгийг зарцуулснаас Халамжийн сангийн төсвөөс улсын мэдээллийн маягт хэвлэх зардлын ангиллаас нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн гарын авлага хэвлүүлэхэд 10,000.0 мянган төгрөгөөр төсвийг үрэлгэн зарцуулсан байна.</p>	1	10,000.0	-	-	1	10,000.0	-	-	-	-	-	-
Дүн	2	507,478.6	-	-	2	507,478.6	-	-	-	-	-	-

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

3.3. Нийцлийн аудиттай холбоотой нийт 1,992,343.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 1,992,343.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 705,412,140.2 мянган төгрөгийн зарлагын 123 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 1,286,931,063.3 мянган төгрөгийн орлогын 107 гүйлгээ, Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбартай холбоотой 345.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг тус тус хугацаа хоцроож байршуулсан.	1	1,992,343,548.5	1	1,992,343,548.5				-	-
Дүн	1	1,992,343,548.5	1	1,992,343,548.5	-	-	-	-	-